



178

**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2020 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/135

Ховд

**Үнэлгээний хороо байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Ерөнхий боловсролын 7 дугаар сургуулийн дотуур байрны зөөлөн эдлэл, ор, урлагийн заалны тохижилт /Жаргалант сум/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Ш.Нохойжав	-Орон нутгийн өмчийн газрын дарга
Гишүүдэд:	Б.Мөнхцэцэг	- 7 дугаар сургуулийн нягтлан бодогч
	Т.Цэвэлмаа	-Төрийн бус байгууллагын төлөөлөл
	М.Энхжаргал	-Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Э.Цолмон -Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2.Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ш.Нохойжав/-нд даалгасугай.

3.Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга / Э.Цолмон /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

2020 тг А/135 Ch  
02 00849